



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/255

Бат-Өлзий сум

**Шууд гэрээ байгуулах тухай**

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны төсвийн тодотгол батлах тухай” 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22/01 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтын тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ажлын хэсгийн 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг үндэслэн Мод үржүүлгийн газарт шилмүүст болон навчит модны үр, мөчир үржүүлэх “Хүлэмж” худалдан авах ажлыг “Нарлаг ган хүлэмж” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай шууд худалдан авах гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.

2.“Нарлаг ган хүлэмж” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, Мод үржүүлгийн газарт шилмүүст болон навчит модны үр, мөчир үржүүлэх “Хүлэмж” худалдан авах ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.“Нарлаг ган хүлэмж” хязгаарлагдмал хариуцлагатай компанид ажилд шаардагдах 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийг гэрээнд заасны дагуу Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ

